



Соёлын өвийн үндэсний төв



ШУА-ийн Археологийн хүрээлэн

**ХӨВСГӨЛ АЙМГИЙН ТҮНЭЛ СУМЫН НУТГААС САНАМСАРГҮЙ
ИЛРҮҮЛСЭН ЭРТНИЙ ОЛДВОРУУДЫГ ШИЛЖҮҮЛЭН АВЧРАХ, ОЛДСОН
ГАЗРЫГ НЯГТЛАН ШАЛГАХ СУДАЛГААНЫ БАГИЙН ТАЙЛАН**

Тайлан бичсэн:

Ж.Баярсайхан /МПХТШУХ-ийн судлаач, доктор/

Г.Анхсанаа /СӨҮТ-ийн Авран хамгаалах газрын дарга/

Б.Анхбаяр /Археологийн хүрээлэнгийн ЭША, доктор/

Улаанбаатар 2021

Гарчиг

Удиртгал

1. Албан бичгүүд
2. Мөрөн суманд гүйцэтгэсэн судалгаа
 - 2.1. Олдвор хүлээлцсэн тухай
 - 2.2. Хүрэл тогоо болон бусад хүрэл эдлэлүүд
 - 2.3. Цутгуурын чулуун
3. Түнэл сумын нутагт хийсэн судалгаа
 - 3.1.Цагаан толгойн дурсгалт газар
 - 3.2.Яргайтын амны дурсгал
 - 3.3. Сахалтын амны дурсгал
 - 3.4. Жаргалантын хадны зураг /Г.Анхсанаа/
 - 3.5. Талын толгойн хүн чулуун хөшөө /Б.Анхбаяр/
 - 3.6. Үертийн тагийн хүн чулуун хөшөө /Б.Анхбаяр/
4. Тариалан сумын нутагт хийсэн судалгаа
 - 4.1. Зүлэгтийн голын Жаргалантын үзүүрийн дурсгал
5. Их-Уул сумын нутагт хийсэн судалгаа
 - 5.1. Тавцаг толгойн дурсгал
6. Рашаант сумын нутагт хийсэн судалгаа
 - 6.1. Гүүтийн амны дурсгал
 - 6.2.Сандал уулын дурсгал
 - 6.3. Хүрэн толгойн хадны зураг
 - 6.4. Хүн чулуу
 - 6.5. Залаатын амны тахилын онгон


УДИРТГАЛ

Хөвсгөл аймгийн Түнэл сумын уугуул, Мөрөн сумын “Авьяас” дунд сургуулийн дүрслэх урлагийн багш Дэмбэрэлийн Нямтогтох 2020 оны 8 дугаар сард тус сумын 4 дүгээр багийн нутаг Цагаан толгой гэдэг газар ах нарын хамт адууны хашаа цэвэрлэж байгаад санамсаргүй байдлаар газраас төмөрлөг гогцоо цухуйж байхыг хараад малын хөл гэмтээж магадгүй хэмээн авч хаяхаар лавшруулан ухаж үзвэл амсраар нь нийлүүлэн тавьсан хоёр хүрэл тогоо, дотроо зэв маягийн хүрэл эдлэл цутгаж орхисон цутгуурын чулуун хэв зэрэг байсныг олжээ. Энэ тухайгаа Д.Нямтогтох багш 2021 оны 3 дугаар сарын 18-ны өдөр Хөвсгөл аймгийн музейн Эрдэм шинжилгээний ажилтан М.Одмаа, археологич, доктор Ж.Баярсайхан нарт мэдэгджээ.

Археологич Ж.Баярсайханд илгээсэн гэрэл зургуудаас үзэхэд эдгээр олдворууд нь хүрэл, төмрийн түрүү үеийн маш ховор, түүхийн үнэт дурсгал болох нь тодорхой бөгөөд олдсон газрыг нарийвчлан нягтлан судлах зайлшгүй шаардлагатай үүссэн юм.

Соёлын сайдын 2021 оны А/69 дугаар тушаалын (хавсралт 1) дагуу Соёлын өвийн үндэсний төвийн захирал 2021 оны А/32 тоот тушаалаар (хавсралт 2) Ажлын хэсгийн бүрэлдэхүүн, удирдамжийг (хавсралт 3) батлан, Соёлын өвийг авран хамгаалах газрын дарга Г.Анхсанаа, ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, доктор Б.Анхбаяр, Монголын үндэсний музей болон ХБНГУ-ын Макс планкийн хүний түүхийн шинжлэх ухааны хүрээлэнгийн судлаач, доктор Ж.Баярсайхан нарын бүрэлдэхүүнтэй баг 2021 оны 5 дугаар сарын 24-нөөс 30-ны хооронд ажиллаа.

Түүнчлэн хээрийн судалгааны хугацаанд зам дагуу Түнэл сумын нутаг Яргайтын ам, Сахал, Жаргалант, Талын толгой, Таг, Тариалан сумын Зүлэгтийн голын Жаргалантын үзүүр, Их-Уул сумын Тавцаг толгой, Рашаант сумын Гүүтийн ам, Сандал уул, Хүрэн толгой, Тохойн тал, Залаатын ам зэрэг зарим археологийн дурсгалт газруудаар дайрч бүртгэн баримтжуулах ажлыг хийсэн болно.



Зураг 1. Хээрийн судалгаа хийсэн чиглэл

1. АЛБАН БИЧГҮҮД



МОНГОЛ УЛСЫН СОЁЛЫН САЙДЫН ТУШААЛ

2021 оны 05 сарын 05 өдөр

Дугаар А/69

Улаанбаатар хот

Археологийн авран хамгаалах судалгааны зардал шилжүүлэх тухай


Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2, 14.2.3, 14.4, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Өмнөговь аймгийн Номгон сумын Авдарант хайрхан, Хөвсгөл аймгийн Түнэл сумын Цагаан толгой хэмээх газруудад илэрсэн дурсгалыг хамгаалах, тухайн орчинд археологийн авран хамгаалах судалгаа хийхэд шаардагдах зардлыг хавсралт ёсоор баталсугай.

2. Авран хамгаалах судалгаа хийхэд шаардагдах нийт 5,226,000.0 (таван сая хоёр зуун хорин зургаан мянган) төгрөгийг Түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах зардлаас гаргаж, зарцуулах эрхийг Соёлын өвийн үндэсний төв (Г.Энхбат)-д шилжүүлэхийг Санхүү, хөрөнгө оруулалтын газар (Ж.Отгонбат)-т зөвшөөрсүгэй.

3. Судалгааг Шинжлэх ухааны академийн Археологийн хүрээлэнтэй хамтран зохион байгуулж, зардлыг зориулалтын дагуу зарцуулж, тайлагнахыг Соёлын өвийн үндэсний төв (Г.Энхбат)-д үүрэг болгосугай.

САЙД



Ч.НОМИН



20210520
14192310100

Соёлын сайдын 2021 оны А/69 дүгээр тушаал



СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2021 оны 05 сарын 18 өдөр

Дугаар А/32

Улаанбаатар хот

Авран хамгаалах ажлын
зардал гаргах тухай

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.6 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Соёлын сайдын А/69 тоот тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Өмнөговь аймгийн Номгон сумын Авдрант хайрхан хэмээх газар дахь эртний хадны оршуулга олж мэдсэн мэдээллийг шалгах авран хамгаалах багийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, Хөвсгөл аймгийн Түнэл сумын Цагаан толгой хэмээх газарт илэрсэн олдворуудыг шилжүүлэн авч ирэх багийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Дээрх ажилд шаардагдах нийт 5 226 000 (Таван сая хоёр зуун хорин зургаан мянга) төгрөгийг төсвийг дагуу гаргахыг Ерөнхий нягтлан бодогч (Ч.Өнөртогтох)-т зөвшөөрсүгэй.

3. Авран хамгаалах ажлын тайланг 2021 оны 6 дугаар сарын 10-ны дотор тайлагнахын багийн ахлагч ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн захирал (Г.Эрэгзэн) ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан (С.Хүрэлсүх) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ

Г.ЭНХБАТ



20210520

1421000064

Соёлын өвийн үндэсний төвийн захиралын 2021 оны А/32 дугаар тушаал

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДСЭНИЙ ТӨВИЙН
ЗАХИРАЛ

БАТЛАВ:.....Г.ЭНХБАТ

ШУА-ИЙН АРХЕОЛОГИЙН ХҮРЭЭЛЭНГИЙН
ЗАХИРАЛ

БАТЛАВ:.....Г.ЭРЭГЗЭН

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ТҮНЭЛ СУМЫН НУТГААС САНАМСАРГҮЙ ИЛРҮҮЛСЭН ЭРТНИЙ
ОЛДВОРУУДЫГ СОЁЛЫН ЯАМАНД ШИЛЖҮҮЛЭН АВЧРАХ, ОЛДСОН ГАЗРЫГ НЯГТЛАН
ШАЛГАХ СУДАЛГААНЫ БАГИЙН УДИРДАМЖ, ТӨСӨВ

1. Судалгааны зорилго:

Хөвсгөл аймгийн Түнэл сумын уугуул, Мөрөн сумын “Авьяс” дунд сургуулийн Дүрслэх урлагийн багш Дэмбэрэлийн Нямтогтох 2020 оны 8 дугаар сард Түнэл сумын 4 дүгээр багийн нутаг Цагаан толгой гэдэг газар ах нартайгаа хамт адууны хашаа цэвэрлэж байгаад санамсаргүй байдлаар газраас төмөрлөг гогцоо цухуйж байхыг хараад малын хөл гэмтээж магадгүй хэмээн авч хаяхаар лавшруулан ухаж үзвэл амсраар нь нийлүүлэн тавьсан хоёр хүрэл тогоо, дотор дотроо жад маягийн хүрэл эдлэл цутгаж орхисон цутгуурын чулуун хэв зэрэг байсныг олжээ. Энэ тухайгаа Д.Нямтогтох багш 2021 оны 3 дугаар сарын 18-ны өдөр Хөвсгөл аймгийн музейн Эрдэм шинжилгээний ажилтан М.Одмаа, археологич, доктор Ж.Баярсайхан нарт мэдэгджээ. Түүний мэдээлснээр эдгээр олдворууд өдгөө өөрийнх нь гэрт хадгалагдаж байгаа аж. Археологич Ж.Баярсайханд илгээсэн гэрэл зургуудаас үзэхэд эдгээр олдворууд нь Монголын Хүрэл, төмрийн түрүү үеийн маш ховор, түүхийн үнэт дурсгал болох нь тодорхой бөгөөд олдсон газрыг нарийвчлан нягтлан судлах зайлшгүй шаардлагатай байна. Тиймээс Монгол улсын Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 27.1, 27.2, 27.5, 27.6, 27.7, 30.1, 30.3 дахь заалтыг тус тус үндэслэн эдгээр олдворыг авран хамгаалах, түүхэн үнэ цэн, материал, он цагийг тогтоох нарийвчилсан судалгаа хийх, олдворуудыг шилжүүлэн авчрах, дурсгалт газрыг нягтлан судлах зорилгоор энэхүү судалгааны багийг илгээж байна.

2. Хугацаа

2021 оны 5 дугаар сарын 22-ноос 5 дугаар сарын 29-ний өдрийг дуустал 7 хоног

3. Хээрийн судалгааны ангийн бүрэлдэхүүн

Г.Эрэгзэн (ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн захирал, доктор, дэд профессор)

Г.Анхсанаа (СӨҮТ-ийн Авран хамгаалах газрын дарга, докторант)

Ж.Баярсайхан (Монголын үндэсний музей болон ХБНГУ-ын Макс планкийн хүний түүхийн шинжлэх ухааны хүрээлэнгийн судлаач, доктор)

Ц.Ганзориг (Жолооч)

4. Хөдлөх хүч

Land Cruiser Prado 150 УБР 56-93

5. Судалгааны ангийн чиглэл

Судалгааны анги нь Улаанбаатар – Мөрөн –Түнэл – Мөрөн- Улаанбаатар хот гэсэн чиглэлээр зорчин явна.


6. Судалгааны ангийн гүйцэтгэх ажил

Археологийн авран хамгаалах судалгаа, олдворуудыг шилжүүлэн авчрах, дурсгалт газарт анхан шатны судалгаа хийх.

7. Урьдчилсан үр дүн

Эдгээр ховор олдворуудыг Монгол улсын соёлын өв санд албан ёсоор шилжүүлэн авснаар Монголын соёлын өв сан баяжихаас гадна, Монголын хүрэл төмрийн түрүү үеийн түүхийн судалгаа, ялангуяа Монголын умард бүс нутгийн эртний төмөрлөг үйлдвэрлэлийн талаар тодорхой бодит баримтад тулгуурлан судалгааны шинэ санал дүгнэлт гаргах бүрэн боломжтой болох юм. Түүнээс гадна олдсон газарт цаашид нарийвчлан судалгаа явуулж, Монголын умард бүс нутаг дахь хүрэл үйлдвэрлэлийн дурсгалт газрыг илрүүлэн судлах боломжтой хэмээн урьдчилсан байдлаар үзэж байна.

Удирдамж боловсруулсан:



Г.Анхсанаа
Ж.Баярсайхан

-х-

Ховсод аймгийн Тхэрэн
сүмийн нутгаас олгосон
зарим олгворын хурт
атах тухай

2020 оны 8-р сарын сүүлээр
Тхэрэн сүмийн нутаг 4-р баг Цагаан
толгой хэмтх газраас Дэлгэрхийн
Нягтгосох, Д Отгондотой, Д. Дондсайхан
иэр ажурин хамнаа барих үеэ
гозраас цухуйж байсан үеэсээ бүрхлийг
ухаж ~~цухуйж~~ цухуйж 2м хурт тосго,
3м хурт 3в(?) бүхий цутгээрвэл
хэвийн хамт ~~олт~~ олт в.

Эдгээр ил хурт хамт и
байгварынгаа хурт хамт өхдөр
мэдэгдэн байна. Чух

- Хурт тосго 2м (тол, хамнаа)
иэрвэл хамт 2м
- 3м 3в бүхий цутгээрвэл хурт
хэв (2м)
- 53 иэрхн хурт хурт байна.
- Ойл хурт хамт өсөн: ~~Хамт~~ /Хамт хамт/

Хурт авсан: 

Мөр 2024-5-25-сү


2. МӨРӨН СУМАНД ГҮЙЦЭТГЭСЭН СУДАЛГАА

2.1. Олдвор хүлээлцсэн тухай

Хээрийн судалгааны баг дээрх олдворыг олж, гэртээ хадгалж байсан Д.Нямтогтох багштай гэрт нь очиж уулзан, Хөвсгөл аймгийн Боловсрол, соёл, урлагийн газрын Соёлын өв хариуцсан мэргэжилтэн Х.Баасансүрэнг байлцуулан олдворуудыг акт үйлдэн хүлээн авлаа (Өмнөх хуудсанл буй олдвор хүлээн авсан актыг харна уу). Үүнд, Суурь нь салсан бүтэн хүрэл тогоо 2 ш, цутгуурын чулуун хэв 2 ш, хүрэл зэвний онги цутгах зориулалтай хүрэл эдлэл 3 ш, хүрэл ооль 1 ш болон жижиг, том хүрэл эдлэл 53 ш байна.


2.2. Хүрэл тогоо, ооль болон бусад хүрэл эдлэл

1 дүгээр хүрэл тогоо: Өндөр суурьтай, үл ялиг зуувандуу дэрвэгэр амсартай, амсраас доош нарийссан шувтан хэлбэртэй. Их биеэс дээш үргэлж цутгасан дугуй хэлбэрийн босоо сэнжтэй. Сэнжийг цутгахдаа тогооны их биед хагас дугуй хэлбэр дээр сам маягийн хувилдсан чимэглэлийг товойлгон гаргасан бөгөөд сэнжний голоор нарийн ховилтой. Их биеийн дундуур нарийн гүвгэр бүслүүртэй. Суурийг тусад нь цутгаж, тогооны их биетэй залгасан, ёроол зуувандуу, үл ялиг гадагш



дэрвэгэр бөгөөд ёроол нь тэгш биш хэмтэй. Гадна, дотор талдаа галд түлэгдсэн тортогтой. Тогооны өндөр 46.2 см, амсрын тойрог 111 см (амсрын хамгийн өргөн хэсгийн голч 36 см), сэнжний өндөр 7.5 см, өргөн 9.4 см, суурийн өндөр 7.4 см, суурь тогооны их биетэй 9 см голчоор залгагдсан бөгөөд ёроол зуувандуу 10.5x12 см хэмжээтэй. Хүрэл тогооны амсрын хэсэг 0.9 см, их биеийн хэсэг 0.3-0.4 см, суурийн хэсэг 0.7-1.2 см зузаантай. 12.2 кг жинтэй.

2 дугаар хүрэл тогоо: Өндөр суурьтай, үл ялиг гадагш дэрвэгэр амсартай. Асмараас доош нарийссан, шувтан хэлбэртэй. Их биеэс дээш үргэлж цутгасан, дугуй хэлбэрийн босоо сэнжтэй. Сэнжийг их биед суулгасан маягтай цутгасан бөгөөд дээр нэг товруутай, дундуур нь нарийн ховилтой. Нөгөө сэнж угаасаа хугарч алга болсон. Тогооны их биеийн



дундуур нарийн гүвгэр бүслүүртэй. Суурийн дээд болон ёроол зөв дугуй хэлбэртэй бөгөөд тусад нь цутгаж тогооны их биетэй залгасан. Гадна, дотор талдаа галд түлэгдсэн тортогтой. Тогооны өндөр 38.5 см, амсрын тойрог 92 см, (амсрын голч 28.5 см), сэнжний өндөр 6.5 см, өргөн 7.8 см, суурийн өндөр 11 см, суурь тогооны их биетэй 6.3 см голчоор залгагдсан дундаа 1.6 см нүхтэй бөгөөд ёроол хэсэг 12.9 см хэмжээтэй. Хүрэл тогооны амсрын хэсэг 0.8 см, их бие хэсэг 0.3-0.4 см, суурийн хэсэг 0.3 см зузаантай. 7 кг жинтэй.

Чихтэй хүрэл ооль: Хэвэнд цутгаж үйлдэх үед гарсан ирмэг ойлны хоёр тал, чихний орчмоор мэдэгдэх бөгөөд иш суулгах хэсгийн нэг өргөн тал, чихний хамт хугарч унасан. Иш суулгах хөндий хэсгийн ирмэг гүвгэртэй бөгөөд дунд талд жижиг хонхор мэдэгдэнэ. Ойлны урт 11.9 см (үзүүрийн цул хэсэг 3.2 см), өргөн 5.8 см, одоо байгаа зузаан 2.6 см. Хөндий хэсгийн зузаан 0.3 см хэмжээтэй. 216.10 гр жинтэй.

2.3. Цутгуурын чулуун хэв

Уг чулуун хэв нь Цагаан толгойгоос олдсон олдворуудын дотроос хамгийн чухал түүхийн баримт хэрэглэгдэхүүн юм. Уг хэвийг баргилт чулуугаар хийжээ. Нийт жин 797.29 гр, Хэмжээ нь 9.8 см урт, 7.4 см өргөн, 6 см зузаан. Уг чулуун хэв нь нийт таван хэсгээс бүрдэх бөгөөд үүнд, хоёр талаас хавсарч тэгш гадаргуугаар нийлдэг хоёр тусдаа чулуун хэвнээс гадна хэвний дотор талд гурван сумны зэв цутгахад онгины хөндий нүх гаргах зориулалтай гурван хүрэл нэмэлт хэсгүүдтэй. Чулуун хэвний нэг нь 9.8 см урт, 7.5 см өргөн, 3.2 см зузаан, нөгөө нь 9.8 см урт, 7.5 см өргөн, 2.8 см зузаан. Хоёр чулуун хэвний нийлдэг тэгш гадаргуу дээр 4.5-5 см урт, 1.4 см өргөн, 1.2-1.3 см урт, 0.9-1 см голчтой

онги бүхий гурван зэвийг хоёр талаас хавсарч цутгахаар төлөвлөж, ижил хэмжээтэйгээр хонхойлгон сийлжээ. Тийнхүү сийлэхдээ зэвний онгин хэсгийг цутгах хэсэгт хажуудаа гогцоо сэнжтэй гурван хүрэл эдлэлийг тэдгээрийн хэмжээгээр хэвэнд суухаар хонхойлгон сийлсэн бөгөөд энэхүү гурван хүрэл хэсгүүд нь зэвний мөс суух онгины хөндий нүхийг гаргах зориулалтай аж. Эдгээр хүрэл хэсгүүд болон хэвний сийлбэрээс харахал зэвний онгинд мөс суух гүн 1.4-1.5 см байна. Хүрэл хэсгүүд нь өөр хоорондоо адил жин, хэмжээтэй байна. Үүнд: Нэг дэхь нь 8.06 гр жинтэй, 4.1 см урт, 1.2 см өргөн, 0,9 см зузаан. Хоёр дахь нь 8.99 гр жинтэй, 5 см урт, 1.2 см өргөн, 1 см зузаан. Гурав дахь нь 8.23 гр жинтэй, 4 см урт, 1.2 см өргөн, 0.9 см зузаан тус тус хэмжээтэй байна. Хавсарсан хэвний нэг талаас буюу зэвний толгой талаас цутгуур урсан орохоор бодолцон 3.3 х2.7 см хэмжээтэй зууван дугуй хонхор гаргасан. Нөгөө эсрэг талд нэг хэвэнд 0.9х0.6 см голчтой 1.4 см гүн зууван дугуй нүх ухсан. Мөн энэ талд нэг хэвний булангаас элтэрч хагарсан. Хэвний хайлмаг цутгуур орохоос бусад талуудад хоёр хэвийг хавсран цутгуурыг алдаагүй зөв гарахад зориулан урт талуудад тус бүр 2, богино талд нэг гүн зураас буюу хэмжээс гаргажээ (Зураг).



Зураг. Цутгуурын чулуун хэв

3. ТҮНЭЛ СУМЫН НУТАГТ ХИЙСЭН СУДАЛГАА

Түнэл суманд хийсэн бидний судалгаанд Хөвсгөл аймгийн Соёл, урлагийн газрын мэргэжилтэн Х.Баасансүрэн болон, Түнэл сумын засаг дарга Дампилын Цогбаяр, орлогч дарга Жигжидийн Самбаллхүндэв, Соёлын төвийн эрхлэгч Дамдинсүрэнгийн Түмэнбаяр, дунд сургуулийн Түүхийн багш Магван-Эрдэнийн Ганболд нарын бүрэлдэхүүнтэй хүмүүс газарчлан тусалсан билээ (Зураг). Түүх, соёлын өвийнхөө дурсгалыг танин мэдэх, судлан, сурталчилах үйлсийг ухамсарлан ойлгож, судалгааны багийг дэмжиж ажилласан дээрх хүмүүст гүн талархал илэрхийлье.



Зураг. Судалгааны баг Түнэл сумын удирдлагуудтай хамт Сахалтын аманд /Гэрэл зургийг Б.Анхбаяр/

3.1. Цагаан толгойн дурсгалт газар

Мөн олдворуудыг анх олсон болох Түнэл сумын нутаг хойноос урагш чигтэй урсацтай жижиг голын баруун гар талаас түрж орж ирсэн, урд хойд талаараа үерийн жалга бүхий дэнж дээр барьсан адууны хашаа барьсан байх бөгөөд энэ орчмыг (сумын төвөөс баруун урд зүгт шулуунаар 9 км орчим зайд $49^{\circ} 50'.243''$ $100^{\circ} 30'.421''$ 1632 м) Цагаан толгой хэмээх нэрлэдэг байна. Бид энэ газар очиж гүймэг хайгуул хийж газар зүйн солбицлыг тогтоож, гэрэл зургаар баримтжуулалт хийв (Зураг).



Зураг . Цагаан тоглой орчим



Зураг. Олдвор олдсон адууны хашаа

3.2. Яргайтын амны дурсгалт газар

Энэхүү дурсгалт газар нь Хөвсгөл аймгийн Түнэл сумын төвөөс хойш 15 км зайд УӨ 49.57.904, ДУ 10.44.896 цэгийн солбицолд, ДТД 1427м-ийн өндөрт Эгийн голын хойд бие Яргайтын ам хэмээх газар хоёр буган хөшөө байна. Энд нэг хажуу тийшээ налж хазайсан хөшөө байсныг Түнэл сумын Засаг даргын орлогч Ж.Самбаллхүндэв үзэж, гэрэл зургийг археологич Ж.Баярсайханд илгээснээр буган хөшөө болохыг тогтоожээ. Хөшөөний налуу байдлаас харахад нүүрэн тал нь хойд зүг рүү харж байсан бололтой. Тиймээс хөшөөний анхны зүг чиг алдагдаж, хожим нэгэн цагт хөшөөг буруу харуулан босгосон аж. Үүнтэй холбоотой нэгэн аман мэдээг Түнэл сумын орлогч дарга Ж.Самбаллхүндэв бидэнд өгсөн юм. Тэрээр нутгийн хөгшчүүл хөшөө чулууг хаа нэг газар нэгэн нууц эрдэнэсийн зүг чигийг зааж байсныг цаатай улсууд ирээд юмыг нь олж аваад зүгийг нь буруу харуулсан юм гэнэлээ гэж ярьдаг байсан хэмээн хуучилсан. Бид дурсгалт газарт дээрх буган хөшөөний урд талаас газарт унасан бас нэг буган хөшөөг илрүүлэн олсон билээ. Эдгээр хөшөөдийн эргэн тойронд тахилгын байгууламжууд буйгаас харахад хэдийгээр налж хазайсан, унасан боловч анхны байрлал дээрээ буй илэрхий мэдэгдэж байна (Зураг). Ийнхүү энэ дурсгалт газарт хоёр буган хөшөө буйг бүртгэн баримтжууллаа.



Яргайтын амны дурсгалт газар /ард талаас/

1-р буган хөшөө: Уг хөшөөг хөх саарал боржин чулуугаар хийсэн бөгөөд хажуу тийшээгээ хазайсан налуу байдалтай байна. Хөшөө газраас дээш орой хүртэл 185 см өндөр, 45 см өргөн, 28 см зузаан. Нүүрэн талын дээд хэсэгт хоёр ташуу зураас түүний зэрэгцээ баруун хажууд доороо үрлэн унжлагатай цагираг ээмэг сийлж, тэдгээрийн доогуур хөшөөг тойруулан 16 ширхэг зууван дугуй хонхоруудаар хүзүүний зүүлтийг дүрсэлжээ. Үүнээс доош бүс хүртэлх зайд нүүрэн талд дугуй цагирагаар толь, зүүн хажууд тагнай хээтэй таван талт бамбай дүрсэлж, хөшөөний доод хэсгээр цулгуй шулуун ховилоор бүс, бүснээс нүүрэн талд дугуй толттой, чагтан балтагтай том чинжал хутга зүүснээр тус тус сийлжээ (Зураг).



Яргайтын амны 1 дүгээр буган хөшөө


2-р буган хөшөө: Уг хөшөөг мөн саарал боржин чулуугаар хийжээ. Хөшөөний өндөр нь 125 см, зузаан нь 35 см, өргөн нь 20 см. Хөшөөний нүүрэн талын дээд хэсэгт хоёр ташуу зураас дүрсэлж, түүний доогуур хөшөөг тойруулан 15 ширхэг хонхор дүрсээр хүзүүний зүүлтийг илэрхийлжээ. Түүнээс доош бүс хүртэлх зайд баруун хажууд дугуй цагариган дүрстэй толь дүрсэлж, хөшөөний дундаас доохнуур цулгуй нарийн ховилоор бүс сийлж, баруун хажууд бүсний дор хутга болов уу гэмээр урт гонзгой дүрс тус тус сийлжээ (Зураг).



Яргайтын амны 2 дугаар буган хөшөө

3.3.Сахалтын амны дурсгал

Түнэл сумын төвөөс баруун хойш 32 км зайд Сахалтын ам хэмээх газар урьд өмнө судалгаанд хамрагдаагүй нэгэн чухал дурсгалт газар байсныг нутгийн хүмүүс эртнээс хайрлан хамгаалж иржээ. Энэ дурсгалт газрын тухай анх Алаг-Эрдэнэ сумын орлогч дарга Ё.Даваа археологич Ж.Баярсайханд мэдээлжээ. Судалгааны баг энэ удаа дурсгалт газарт Түнэл сумын орлогч дарга Ж.Самбалхүндэвээр газарчлуулан богино хугацаанд ажиллаж, нийт 160 орчим хиригсүүр, булш, 20 орчим Түрэгийн тахилгын онгон бүхий томоохон цогцолбор буйг бид бүртгэж, анхан шатны баримтжуулалт хийв (Зураг).




Зураг. Сахалтын амны дурсгалын дэвсгэр зураг (*Panthom 3 advanced* дроноор авч, *DroneDeploy*, *ArcMap* програмуудаар боловсруулав)



Зураг . Сахалтын амны дурсгалт газар урд талаас (*Panthon 3 advanced дронн*)

Мөн буган хөшөө байж болохуйц хэд хэдэн газарт нягтлан шалгаж үзэхэд нийтдээ 5 буган хөшөөг шинээр илрүүлэн олов. Эдгээр буган хөшөөний 3 нь (буган хөшөө №1-3) хожим Түрэгийн тахилгын онгоны хашлага, зэл чулуунд дахин ашиглагджээ. Харин хоёр нь (буган хөшөө №4-5) анхны байрлалдаа унасан байдалтай байв. Эхний гурван буган хөшөөний хойд талд 70 гаруй метрийн зайд 55 м голчтой дугуй хүрээтэй 28 м голчтой дугуй чулуун дараастай, хүрээний гадна зүүн урд талдаа 13 ширхэг, баруун хойд талдаа 3 ширхэг буюу нийт 16 ширхэг дугуй чулуун дараастай (1 дүгээр хэлбэрийн) тахилгын байгууламжтай, түүнийг гадуур эргэн тойрон олон жижиг цагираг (2 дугаар хэлбэрийн) тахилгын байгууламжтай нэгэн хиригсүүр бий. Эдгээр буган хөшөөдийг дээр дурдсан хиригсүүр болон Түрэгийн тахилгын онгонуудын баруун талд буй буган хөшөө байсан бололтой 2-3 бүлэг тахилгын байгууламжуудаас зөөн авчирсан бололтой (**Зураг**).



Сахалтын амны буган хөшөөдийн байрлал (№1-3) урд талаас (MavicAir дронн)

1 дүгээр буган хөшөө: Энэ хөшөө газар зүйн УӨ 49.55.424, ДУ 101.03.610 цэгийн солбицолд, ДТД 1307 м-ийн өндөрт, цувраа дөрвөн Түрэгийн тахилгын онгоны урдаасаа хоёр дахь тахилгын байгууламжийн зүүн талд эхний зэл чулуу болгон ашигласан. Газраас дээш цухуйж буй өндөр нь 24см , өргөн нь 24 см, зузаан нь 31 см. Уг хөшөөний зүүн хажууд цагираг ээмэг сийлсний тал хэсэг нь газарт булагдан зөвхөн тал хэсэг нь ил харагдаж байна (Зураг).



Сахалтын амны буган хөшөө №1 /урд талаас/

2 дугаар буган хөшөө: Уг хөшөөг хөх саарал боржин чулуугаар хийсэн бөгөөд 1 дүгээр буган хөшөөний зүүн хажууд буюу дээр дурдсан Түрэгийн тахилгын онгоны хоёр дахь зэл чулуу болгон дахин ашиглажээ. Хөшөөний нүүрэн талыг баруун тийш харуулан босгосон бөгөөд тэр тал дээр хоёр ташуу зураас түүний зэрэгцээ хөшөөний зүүн хажуу талд /өнөөгийн байрлалаар бол урд тал Ж.Б/ дугуй цагариг ээмэг тус тус сийлсэн нь газраас дээш ил харагдаж буй талуудад ил харагдаж байна (Зураг).



Сахалтын амны буган хөшөө №2 /баруун болон урд талаас/

3 дугаар буган хөшөө: Уг хөшөө нь өмнөх хоёр хөшөөг ашигласан Түрэгийн тахилгын онгоны хойд талын тахилгын онгоны баруун хойд буланд хашлага болгон ашигласан байна. Саарал боржин чулуугаар хийсэн уг хөшөөний зөвхөн нэг талын багаахан хэсэг нь ил харагдах бөгөөд бусад хэсэг нь газарт булагджээ. Ил харагдаж буй гадаргуу дээр дугуй хонхоруудаар хүзүүний зүүлт сийлсэн нь тодорхой харагдах бөгөөд эдгээрээс нэг хонхорыг бусдаас нь илүү томоор дүрсэлсэн нь амьтны дүрслэлгүй буган хөшөөний хүзүүний зүүлтний ар шилэн хүзүүн дээрх нэг сувсыг бусдаас илүү томоор дүрсэлсэн байдагтай адил байна (Зураг).



Сахалтын амны буган хөшөө №3 /дээрээс/

Сахалтын амны 4-5 дугаар буган хөшөө нь дурсгалт газрын зүүн урд хэсэгт байрлах 63 м дугуй хүрээтэй, 38 м голчтой чулуун овоолгой бүхий хиригсүүрийн зүүн хажууд хүрээний гадна талд зүүн болон зүүн хойд талд тус бүр нэг унасан буган хөшөө байна. Үүний нэг нь (буган хөшөө №4) хиригсүүрийн хүрээ болон тахилгын байгууламжуудын завсар дахь зайд байгаа бол нөгөөх нь (буган хөшөө №5) хиригсүүрийн хүрээнээс 25 м орчим зайд дугуй чулуун овоолго бүхий 1 дүгээр хэлбэрийн тахилгын байгууламжуудаас гадагш дугуй цагариг хэлбэрийн тахилгын байгууламжуудаас дотогш зайд байрлаж байна (зураг).



Сахалтын амны 4-5 дугаар буган хөшөөний байрлал /агаарын зураг/

4 дүгээр буган хөшөө: Эл хөшөөг саарал боржин чулуугаар хийсэн бөгөөд 120 см өндөр, 24 см зузаан. Газарт булагдсан учраас өргөнийг хэмжих боломжгүй байлаа. Хөшөөний ил харагдаж байгаа талд цулгуй шулуун ховил бүхий бүс, зууван дугуй хонхор дүрсүүдээр илэрхийлсэн хүзүүний зүүлт, цагариг ээмэгний дүрслэлүүд тус тус мэдэгдэж байна (зураг).



Сахалтын амны буган хөшөө №4 /дээрээс/

5 дугаар буган хөшөө: Эл хөшөөг цагаан саарал боржин чулуугаар хийсэн бөгөөд 145 см өндөр, 53 см өргөн. Газарт булагдсан учраас зузааныг хэмжих боломжгүй байлаа. Хөшөөний ил харагдаж байгаа талд өргөн цулгуй ховилоор бүс сийлж, нэг хажуу талд бүснээс сүх зүүсэн байдалтай тус тус дүрсэлжээ. Хөшөөний газарт булагдсан хэсгүүдийг тодорхойлох боломжгүй байв (зураг).



Сахалтын амны буган хөшөө №5 /зүүн хойноос/

Сахалтын амны бурханы хөрөг

Сахалтын аманд Хүрлийн үе, Түрэгийн үеийн дурсгалаас гадна бусад олон үеийн дурсгал буйн нэг нь хавтгай чулууны нэг тал дээр уран нарийн сийлсэн Ногон дарь эх бурханы хөрөг, нөгөө талд түвэд үсгээр бичсэн тарни бүхий шашины дурсгал байна. Уг бурханы хөргийг Сахалтын аманд буй жижиг толгойн орой дээр байна (зураг).



Сахалтын амны Ногоон дарь эх бурханы хөрөг

3.4. Жаргалантын хадны зураг

Түнэл сумын төв Булаг суурингаас зүүн хойш (шулуунаар) 8.2 км зайд Биж багийн нутаг Эгийн голын өмнө орших оройгоороо хадтай багхан уулын урд үзүүрт, зүүн хойноос баруун урагш чигтэй хадан хамарт цөөн хадны сийлмэл зураг байна (N 49° 55'.621" E 100° 40'.272" дтд 1500 м). Энэ хадны зургийг нутгийн иргэд Жаргалантын хадын зураг хэмээн нэрлэж иржээ. Тус хадны зургийн дурсгалт газар хадан хамрын зүүн хажуу талын дунд хирд орших эгц хадны зүүн урагш харсан тэгш гадаргуу дээр бүх талбайгаар нь хонхойлгон сийлсэн бүлэг хадны зураг болон хормой хэсгээр ганц нэг зурагтай хад зэргээс бүрдэнэ. Хадны зургийг дээр нь урлсан хад олон хэсэг цуурсанаас хойд хэсэг нь салж хагарсан байдалтай байна. Түүнчлэн, хадны зураг бүхий хадан хамрын зүүн доор дөрвөлжин хүрээ бүхий нэгэн хиригсүүр байх бөгөөд саяхан голын овоолгыг маш ихээр ухаж, тоносон байдалтай харагдана (зураг).

Зүүн урд зүг харсан эгц хадны дээд хэсэгт 1.3х1.4 м хэмжээтэй орчим талбайн дээд хэсэгт биеийн ерөнхий хэлбэр нь мэдэгдэх төдий янгирын болхи дүрслэл, түүний доор урт хошуу, угалзарсан эвэр, эх бие, 2 хөлийг тодорхой харуулсан буган хөшөөний адилаар хийсвэрлэн урласан бугыг бага зэрэг доош чиглүүлсэн сийлжээ. Энэ бугын хошууны дээд хэсэгт том, жижиг 2 дугуй онги дүрсэлсэн. Үүний доор босоо хэлбэртэй олон салаа эвэр бүхий нэгэн бугыг сийлснээс одоо биеийн ерөнхий хэлбэр болон урд хөл, бөгсөн бие, сүүл зэрэг нь тодорхой харагдаж байна (зураг).

Эдгээр хадны зургийн доор, хадны ёроол хэсэгт 0.4х0.3 см талбайд бүдүүн эвэртэй, биеийн ерөнхий хэлбэр бөгтөрдүү нэгэн бугыг урагш чиглүүлэн сийлжээ. Энэ бугын өмнө талд, хошууны тушаа, (найман ?) цацрагтай дугуй (нарны) дүрс байна. Үүний доор мөн нэгэн бугыг хойш чиглүүлэн, дээрх бугын эсрэг харуулан сийлжээ. Энэ бугыг толгой, эвэр, эх бие, урд хөл одоо тодорхой харагдаж байгаа боловч бөгсөн бие, хондлойг сийлсэн хэсэг хагарч унасан байна (зураг).

Мөн хадат хамрын зүүн урд хормойгоор жижиг хадан дээр үл мэдэгдэх цөөн хэдэн зураг байгаа бөгөөд магадгүй дээрээс нурж унасан бололтой юм.



Зураг. Жаргалантын амны тоногдсон хиригсүүр



Зураг. Жаргалантын амны хадны зураг



Зураг. Жаргалантын амны хадны зураг

3.5. Талын толгойн хүн чулуун хөшөө

Хөвсгөл аймгийн Түнэл сумын төвөөс урагш 17 км зайд Хөндий хэмээх уужим хөндийн төгсгөл баруун урдаас зүүн хойш сунаж тогтсон модтой багахан нуруун ард, Хар усны голын зүүн эрэгт нэгэн хүн чулуун хөшөө бий. Хүн чулуун хөшөөний урдуур буй хэдэн толгойг Талын таван толгой гэх бөгөөд Сул толгой, Ноён толгой, Дунд толгой, Халзан толгой, Үзүүр толгой хэмээнэ. Уг хөшөөг 2021 оны хавар Түнэл сумын иргэн Ж.Самбалхүндэв (Сумын иргэдийн нийтийн хурлын дарга) мэдээлж, сумын Түүх-соёлын дурсгалын тоонд бүртгэжээ. Газарзүйн байршил нь $49^{\circ}48'7.22''$ $100^{\circ}37'38.72''$ солбицолд оршино. Хөшөөг бор саарал өнгийн боржин чулууг засаж үйлдээд зүүн урд зүгт хандуулан босгожээ. Одоо байгаа хэмжээ нь 92 см өндөр, 41 см өргөн, 30 см зузаан. 30 хэм орчим налуу хазайсан. Хөшөөний байдлаас харахад анхны байрлалаасаа хөндлөөгүй бололтой. Дүрслэлийн хувьд толгой мөрийг тодруулан зааглаж цохисон ором мэдэгдэнэ. Нүүр болон бусад эрхтэн хувцас хунар мэдэгдэхгүй, ихэд элэгдэж мөлийжээ (Зураг). Хүн чулууны орчим зэл чулуу, тахилын хашлага чулуу, хэрэм шуудуу мэдэгдэхгүй.



Зураг. Талын толгойн хүн чулууны гэрэл зураг

3.6. Үертийн тагийн хүн чулуу

Хөвсгөл аймгийн төв Мөрөн хотоос зүүн хойш 20 км зайд, Түнэл сумын төвөөс баруун урагш 22 км зайд Үертийн таг хэмээх модтой өндөр уулын зүүн хойд шувтрага, Хүн чулууны таг хэмээх газар нэгэн хүн чулуу бий. Газарзүйн байршил нь 49.43'00.07"100.24'58.00"солбицолд далайн түвшнээс дээш 1650 м өндөрт байрлана. Хүн чулуун хөшөөний өмнө зүгт холгүй Ачмаг нуур хэмээх багавтар нуур бий. Хүн чулуун хөшөөг хар сааралдуу өнгийн боржин чулууг авчраад засалгүй зүүн өмнө зүгт хандуулан босгожээ. Хөшөөний дээд хэсэг нарийн шувтан бол сууриараа өргөн. Уг хөшөө 97 см өндөр, сууриараа 46 см, дээгүүрээ 18 см өргөн, 27 см зузаан. Уг хөшөөнд зөвхөн хүний нүүр малгайг дүрсэлсэн байна. Дүрслэлийн хувьд урт тахир хөмсөгтэй, бүлтгэр том нүдтэй, урт унжуу хамартай, богино нарийвтар амтай, толгой дээрээ богино шовгор оройтой, чихээ дарж унжуулсан малгайтай аж (Зураг). Уг дурсгалыг 2015 онд нутгийн иргэдийн мэдээллийн дагуу Соёлын өвийн бүртгэл мэдээллийн санд бүртгэжээ.



Зураг. Үертийн тагийн хүн чулууны гэрэл зураг



Зураг. Үертийн тагийн хүн чулууны фотограмметр зураглал (Ж.Баярсайхан)

4. ТАРИАЛАН СУМАНД ХИЙСЭН СУДАЛГАА

4.1. Зүлэгтийн голын Жаргалантын үзүүрийн дурсгал

Судалгааны багийн аяллын замд үзэж, судалсан дараагийн дурсгал бол Хөвсгөл аймгийн Тариалан сумын Сэлэнгэ (6 дугаар) багийн нутаг Зүлэгтийн голын Жаргалантын үзүүрийн буган хөшөө, хиригсүүрийн цогцолбор байлаа. Уг дурсгалт газар тариалан сумын төвөөс баруун урагш 16 км зайд Зүлэгтийн голын зүүн бие, Жаргалант уулын¹ өвөрт байрлах ба энд 20 гаруй булш, хиригсүүр таван буган хөшөө цогцолбор байдлаар оршиж байна.

Энэ дурсгалт газар буй нэг буган хөшөөний нэг талын гар зургийг Н.Аварзэд хэмээх багш хүн 1968 оны Шинжлэх ухаан амьдрал сонинд хэвлүүлсэн байдаг². Үүний дараа нэрт газар зүйч О.Намнандорж дурсгалт газрын тухай “Тариалан сум, САА-н нутаг Зүлэгтийн голын эргээр босоо хүн чулуун хөшөө гурав, хэвтээ хүн чулуу хөшөө хоёр буй нь бүгд зурагтай. Жаргалант уулын өвөрт байдаг хэдэн булшны чулуунд сийлсэн бичигтэй хөшөө байдаг” товч дурдсан байдаг³. Үүнээс хойш 2015 онд Хөвсгөл аймгийн Соёл урлагийн газрын мэргэжилтэн Х.Баасансүрэн, тус аймгийн музейн ЭША М.Одмаа нарын бүрэлдэхүүнтэй баг дурсгалт газарт ирж, бүртгэл судалгаа хийжээ. Харин 2018 онд Ц.Төрбат тэргүүтэй судлаачид “Монгол ба бүс нутгийн буган хөшөөний соёл” хэмээх сүржин нэртэй даржин зурагт бүртгэлийн номд энд буй буган хөшөөдийн хэмжээ болон дүрслэлийн талаар ихээхэн алдаатай мэдээлэл хэвлэсэн байна⁴. Тухайлбал буган хөшөө бүрийн хэмжээ, дүрслэлийг бодит байдлаас маш хол зөрүүтэй тодорхойлсон нь шинжлэх ухааны судалгаанд хайхрамжгүй хандсны дээр уг дурсгалыг судлан шинжлэх туршлага дулимаг буйн том илрэл юм. Энэхүү жишээнээс харахад уг бүтээлд зохиогчийн эрхийг бүдүүлгээр зөрчин бусад судлаачдын номноос хуулж, оруулснаас бусад буган хөшөөдийн мэдээлэлд итгэх боломж тун хомс байна. Дээрх бүтээлд уг дурсгалын талаарх эх сурвалжийг Ж.Гантулга, Д.Батсүх, Г.Энхбаяр нарын 2017 онд гүйцэтгэсэн “Хөвсгөл

¹ Энэ уулыг хуучин Оросын газрын зурагт Хурц уул хэмээн тэмдэглэсэн байна.

² Н.Аварзэд. Буган хөшөөг ажихад. Шинжлэх ухаан амьдрал. №4(138) УБ.,1968. Тал 24.

³ О.Намнандорж. Бүтээлийн чуулган. III боть. УБ.2019. тал 536.

⁴ Ж.Гантулга, Н.Баярхүү, Д.Батсүх, Н.Эрдэнэ-Очир, Н.Батболд, Г.Энхбаяр, Б.Өмирбек, Т.Идэрхангай, Ц.Төрбат. Монгол ба бүс нутгийн буган хөшөөний соёл. Монголын археологийн өв. Боть IX. УБ.,2018. Тал415-417.

аймгийн нутагт орших буган хөшөөдийн бүртгэл баримтжуулалтын ажлын тайлан” хэмээн заажээ. Дээр дурдсан ном болон тайланг гүйцэтгэсэн судлаачид наанадаж шинжлэх ухааны ёс зүй, судлаач хүний нэр төр, цаанадаж ШУА-ийн нэр хүндийг үл тоон ийм худал хуурмаг бүтээл гаргасан нь туйлын харамсалтай. Чингээд дээрх худал судалгаа хийгчид болон бидний хийсэн хэмжилт, тодорхойлолт баримтжуулалт судалгааны зөрүүг доор харьцуулан сийрүүлье.

Ц.Төрбат, Ж.Гантулга нарын тодорхойлолт:

Буган хөшөө №1. Хэмжээ: 150х39х20 см. Өнгө: Хөх саарал. Материал: Боржин. Төрөл: Монгол-Өвөр Байгал. Хөшөөний дүрслэл ихэд бүдгэрсэн бөгөөд нүүрэн талд дээш дүүлсэн дөрвөн буга, зүүн талын дээд хэсэгт том, жижиг цагариган ээмэг, хоёр буга, баруун талын доод хэсэгт уулан хээтэй бүс, ар талд дөрвөн бугын дүрслэл бүдэг мэдэгдэнэ. Хөшөөний зүүн талын өргөн талын тэгш гадаргууд улаан зосон будаг ихэнх талбайд хадгалагдан үлджээ.

Бидний тодорхойлолт:

Буган хөшөө №1. Уг хөшөөг хөх саарал өнгийн чулуугаар хийжээ. Өндөр нь 157, өргөн нь 21 см, зузаан нь 42 см. Хөшөөний нүүрэн талд доод хэсэгт уулан болон сүйхэлжин хээтэй бүснээс өөр дүрслэлгүй. Баруун хажуу талийн дээд хэсэгт том, жижиг цагариган ээмэг, түүний дор дөрвөн бугыг дээш цоройлгон хийсвэр байдлаар дүрсэлж, доод талын хоёр бугын завсар нэг адуу сийлжээ. Эдгээр дөрвөн бугын дээрээсээ хоёр дахь бугын сэрвээнээс доош өвчүүний толгой хүртэл хөндлөн гүн ховил гаргасан. Хөшөөний ар талд ямар нэгэн дүрслэлгүй. Харин зүүн хажуу талын дээд хэсэг дороо унжлагатай том цагариг ээмэг, түүний хажууд бас нэг жижиг цагариг дүрслээд тэдгээрийн дор дөрвөн бугыг хийсвэр байдлаар сийлсний доод талын гурван бугыг дээш цоройлгон, дээд талын бугын толгойг доош ташуулдуулан зөрүүлэн сийлжээ. Мөн дунд талын хоёр бугын завсар нэг адууны дүрс бий. Мөн хөшөөний доод хэсэгт чинжал хутганы бариул бололтой дүрслэл булагдсан ёроол хэсгээс дээш ил харагдаж байв (Зураг).

Ц.Төрбат, Ж.Гантулга нарын тодорхойлолт

Буган хөшөө №2. Хэмжээ: 280х62 см. Өнгө: Улаан хүрэн. Материал: Боржин. Төрөл: Монгол-Өвөр Байгал. Тахилгын байгууламжийн дэргэд унасан байдалтай бий. Хөшөөний

дээшээ харсан тал дээр хос унжлагатай цагариган ээмэг, гурван том буга, нэг жижиг буга, ар талд хоёр буга, нүүрэн талд дөрвөн буга дэгээ зэргийг тус тус дүрсэлжээ.

Буган хөшөө №3. Хэмжээ: 115х45.5х25 см. Өнгө: Улаан хүрэн. Материал: Боржин. Төрөл: Монгол-Өвөр Байгал. Хөшөөний дүрслэл муу мэдэгдэх бөгөөд нүүрэн талд таван бугын бүдэг дүрс, зүүн талын дээд хэсэгт том, жижиг цагариган ээмэг, дунд хэсэгт дөрвөн бугын дүрслэл мэдэгдэнэ.

Буган хөшөө №4. Хэмжээ: 190х55х28 см. Өнгө: Улаан. Материал: Боржин. Төрөл: Монгол-Өвөр Байгал. Уг хөшөө нь ихэд эмтэрч гэмтжээ. Нуурэн талын орой хэсэгт нарийн зуулт, дунд хэсэгт бугын эврийн хэсэг, доод хэсэгт нэг буга, баруун талын дээд хэсэгт унжлагатай цагариган ээмэг, дөрвөн буга, ар талд хоёр буга, таван талт жижиг бамбай, зүүн талд цагариган ээмэг, таван буга, бүс зэргийг тус тус сийлжээ.

Буган хөшөө №5. Хэмжээ: 252х47х39 см. Өнгө: Улаан хүрэн. Материал: Боржин.Төрөл: Монгол-Өвөр Байгал. Хөшөөний нүүрэн талын дээд хэсэгт нарийн зүүлт, дунд хэсэгт гурван буга, баруун талын дээд хэсэгт цагариган ээмэг, хоёр том буга, байлдааны зээтүү, ар талд гурван буга, доод хэсэгтбугын угалзарсан эвэр, зүүн талын дээд хэсэгт цагариган ээмэг, зүүлт% таван буга, чичлүүр хутга, бамбай зэргийг тус тус дүрсэлжээ.

2-р буган чулуун хөшөө (Хэвтээ) 287х63 см

49 28.744

101 55.655 1039 м

3-р буган чулуун хөшөө 111х44х26 см

49 28.689

101 55.602 1041 м

4-р буган чулуун хөшөө 185х52х30 см

49 28.672

101 55.545 1040 м

5-р буган чулуун хөшөө 240х45х32 см

49 28.625


101 55.465 1038 м

САНДАЛ УУЛЫН (ЦЭНДИЙН) ДЭНЖИЙН ДУРСГАЛТ ГАЗАР

Хөвсгөл аймгийн Рашаант сумын төвийн өмнө Сандал уул хэмээх сүрлэг хайрхан дүнхийнэ. Энэ хайрханы зүүн хойд талын тэгш дэвсэгийг нутгийнхан “Цэндийн дэнж” гэж нэрлэдэг. Ийн нэрлэх учир нь уг дэнж дээр Монгол улсын баатар Г.Цэндийн дурсгалд зориулсан чулуун хөшөө бий. Гомбын Цэнд (1895-1932) бол Монгол улсын баатар цолтой хоёрхон эмэгтэйн нэг бөгөөд Хөвсгөл аймгийн Рашаант сумын хамтралын дарга ажиллаж байгаад 1932 оны эсэргүү бослогын үеэр босогчдын гарт алтан амиа алдсан түүхтэй хүн. Түүний гавьяаг үнэлэн 1974 онд БНМАУ-ын баатар цол нэхэн олгожээ.

Энэ дэнж дээр Г.Цэндийн хөшөө дурсгалаас гадна эртний олон чухал дурсгал зэрэгцэн оршино. Эдгээрийн ихэнх нь Хүрлийн үеийн булш, хиригсүүрүүд бөгөөд нийт 30 орчим тоотой байна. Үүнээс 17 нь дөрвөлжин хүрээтэй, 9 нь дугуй хүрээтэй хиригсүүр, бусад нь хүрээгүй дугуй хэлбэртэй булш, нэг зуувандуу дөрвөлжин хэлбэртэй голдоо чулуугүй том чулуун байгууламж, нэг буган хөшөө тус тус байна (Зураг). Эл буган хөшөө нь дурсгалт газрын баруун зах орчимд буй дугуй болон дөрвөлжин хүрээтэй ижил хэмжээний хоёр хиригсүүрийн зүүн өмнөд талд газарт унаж, хөрсөнд булагдсан байдалтай байв (Зураг). Уг хөшөөг Рашаант сумын Соёлын төвийн эрхлэгч Л. Баярцэнгэл нутгийн хүмүүсийн мэдээллийн дагуу олж үзсэн байв.

Бид эл хөшөөг тойруулан хөрсийг суллаж, хөшөөг бүрэн бармтжуулж, гэрэл зураг авч, гар зураг хийсэн болно. Уг буган хөшөө нь 142 см өндөр, 18 см өргөн, 80 см зузаан. Саарал боржин чулуугаар хийжээ. Хөшөөний нэг өргөн талд нийт зургаан бугыг хийсвэрлэн сийлсний дөрвийг бүтэн, хоёрыг нь зөвхөн толгой хүзүү хэсгийг тухайн орон зайд нийцүүлэн тус тус дүрсэлжээ. Нөгөө өргөн талд гурван бугыг бүтнээр хийсвэр байдлаар сийлснээр уг хөшөөнөө нийт 9 буга сийлсэн байна. Уг хөшөөнд ашигласан чулууны хэлбэрээс хамааран хөшөөний нарийн талууд буюу урд болон ар талд ямар нэгэн сийлбэр хийсэнгүй (Зураг). Энэхүү буган хөшөө нь Монголын археологийн судалгаанд шинээр бүртгэгдсэн судлагдаж буй дурсгал юм.



Зураг. Сандал уулын (Цэндийн) Дэнжийн цогцолбор дурсгалт газрын дэвсгэр зураг



Зураг. Сандал уулын (Цэндийн) Дэнжийн буган хөшөө

Хөвсгөл, Рашаант
Цэндийн дэнж
Буган хөшөө №1
Хэмжээ: 142x80x18 см
Гэр зургийг Ж.Баярсайхан
2021 он



Зураг. Сандал уулын (Цэндийн) Дэнжийн буган хөшөөны гар зураг